



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2025.01.17 № 61287

танай -ны № -т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР, ЭРҮҮЛ
МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ,
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ, АЙМАГ,
НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Тушаал хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны "Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай" А/480, А/739 тоот тушаалыг шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/525, А/265 дугаар тушаалаар батлуулаад байна.

Уг тушаалаар оюутан, суралцагчдыг эрт илрүүлэгт хамруулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах талаар зохицуулалтыг оруулсан. Иймд дээрх тушаалыг үйл ажиллагаандаа тусгаж ажиллана уу.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/525, А/265 дугаар тушаалыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА Л.БАТТӨР



144250201

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
БОЛОВСРОЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2024 оны 16 дугаар
сарын 24-ны өдөр.

Дугаар № 8/15, А/265

Улаанбаатар хот.

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.24 дэх заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Суралцагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ийг нэгдүгээр, “Суралцагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах мэдээллийн урсгал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар (Л.Баттөр)-т, Боловсролын яамны Дээд боловсролын газар (Ж.Ариунболд)-т, Мэргэжлийн болон техникийн боловсролын газар (У.Өлзийцэцэг)-т, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (С.Ням-Очир), Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т, Боловсролын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны хамтарсан “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай” А/480, А/739 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Эрүүл мэндийн сайд, Боловсролын
сайдын хамтарсан 2024 оны 11 дугаар
сарын 11-ны өдрийн 816, 4265 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

СУРАЛЦАГЧДЫГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчдыг (цаашид хамтад нь суралцагч гэх) эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ (цаашид эрт илрүүлэг гэх)-нд хамруулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Үйл ажиллагааны зохион байгуулалт

- 2.1. Суралцагч эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг өөрөө хагас жил, эсхүл жил бүр эрүүл мэндийн даатгалын санд төлнө.
- 2.2. Боловсролын сургалтын байгууллага суралцагчдыг эрт илрүүлэгт хамруулах үйл ажиллагааг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж, жил бүр үр дүнг тооцож ажиллана.
- 2.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь суралцагчдыг боловсрол, сургалтын байгууллагаар дамжуулан эрт илрүүлэгт хамруулахад Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагатай холбон зуучилна.
- 2.4. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын дунд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, сурталчлах, мэдээ, мэдээллээр хангана.
- 2.5. Орон нутгаас нийслэлд ирж суралцаж байгаа суралцагчид харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авна.
- 2.6. Хувь хүний нууцын тухай хуулийг мөрдөж ажиллана.
- 2.7. Суралцагчдыг эрт илрүүлэгт хамруулах, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулна.

Гурав. Байгууллагуудын чиг үүрэг

- 3.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага доор дурдсан чиг үүрэгтэй:

3.1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, нөхцөл байдалд бодлогын судалгаа хийх, дүгнэлт гаргах, судалгаа, шинжилгээ, нотолгоонд

суурилсан хэрэгцээ шаардлагыг бодитой үндэслэж, төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.1.2.Суралцагчдын эрүүл мэндийн байдлыг тандах, судлах, бусад салбартай мэдээлэл солилцох, бодлого, зохицуулалтын арга хэмжээг авна.

3.1.3.Суралцагчдыг эрт илрүүлэгт хамруулах, жил бүр эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх эрүүл мэндийг дэмжих нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, нэгдсэн удирдлагаар хангана.

3.2.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага доор дурдсан чиг үүрэгтэй:

3.2.1.Эрт илрүүлгийг зохион байгуулахад харьяалах нутаг дэвсгэрийн суралцагчдыг хамруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллана.

3.2.2.Суралцагчдын эрүүл мэндийн мэдээлэлд үндэслэн холбогдох хариу арга хэмжээг авч ажиллана.

3.2.3.Суралцагчдын дунд жил бүр эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх эрүүл мэндийг дэмжих нөлөөллийн үйл ажиллагааг холбогдох салбартай хамтран зохион байгуулна.

3.2.4.Тайлан, мэдээг нэгтгэн дүгнэлт хийж, жил бүрийн 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.3.Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар доор дурдсан чиг үүрэгтэй:

3.3.1.Суралцагчдад эрүүл мэндийн боловсрол олгох, эрт илрүүлэгт хамруулах үйл ажиллагааг сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, жил бүр үр дүнг тооцож ажиллана.

3.3.2.Суралцагчдад эрт илрүүлэг хийх эрүүл мэндийн байгууллагуудын хуваарь гарган удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.

3.3.3.Суралцагчдын дунд эрт илрүүлгээр илэрсэн өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавина.

3.3.4. Эрт илрүүлэг болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулсан тухай тайлан мэдээг нутаг дэвсгэрийн хүрээнд нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлнэ.

3.4.Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв доор дурдсан чиг үүрэгтэй:

3.4.1.Салбар дундын оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн, нотолгоонд

суурилсан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргэнэ.

3.4.2.Суралцагчдыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, эрүүл мэндээ дэмжих нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, суралцагчдад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрт илрүүлгийн арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, мэдээлэх, хянах, салбарын болон салбар хоорондын уялдаа, байгууллагуудын оролцоог хангана.

3.4.3.Эрт илрүүлэгт хамрагдах хуваарийн талаарх мэдээлэл, сурталчилгааны материалын нэгдсэн загварыг гаргаж, боловсролын сургалтын байгууллага, эрүүл мэндийн байгууллагуудад түгээж, байгууллагын цахим хуудсанд байршуулна.

3.4.4.Эрт илрүүлгийн ач холбогдлыг таниулж, хуваарийн дагуу хамрагдахыг уриалсан мэдээллийг шинжлэх ухааны нотолгоонд түшиглэн боловсруулж, мэдээллийн бүх төрлийн сувгаар хүртээмжтэй түгээнэ.

3.4.5.Боловсролын байгууллагатай хамтран суралцагчдын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг жил бүр зохион байгуулна.

3.4.6. Суралцагчдын эрүүл мэндийн мэдээллийн санг бүрдүүлж, суралцагчдын дунд зонхилон тохиолдож буй халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4.7.Аймаг, нийслэлээс ирүүлсэн үзлэгийн нэгдсэн тоо, үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн дүгнэлт хийж, жил бүрийн 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.5.Эрүүл мэндийн хөгжлийн төв доор дурдсан чиг үүрэгтэй:

3.5.1.Суралцагчдын эрт илрүүлгийн хамрагдалт, эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээллийг авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангана.

3.5.2.Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлого, шийдвэрт дэмжлэг үзүүлэх, эрт илрүүлгийн тооцоолол дүн шинжилгээ хийнэ.

3.6.Дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага доор дурдсан чиг үүрэгтэй:

3.6.1.Суралцагчдыг хуваарийн дагуу эрт илрүүлэгт хамруулах, оролцоог хангах үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар зохион байгуулж, нөлөөллийн үйл ажиллагааг тасралтгүй явуулж, үр дүнг тооцно.

3.6.2.Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран суралцагчдын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, эрт илрүүлгийг жил бүр зохион байгуулна.

3.6.3.Суралцагчдын эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн үйл ажиллагааг зохицуулна.

3.6.4.Суралцагчдын эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт, эрт илрүүлэгтэй холбогдох зохицуулалтыг дотоод дүрэм, журамдаа тусгана.

3.6.5.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3-д заасан үүргийг хүлээнэ.

3.7.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар доор дурдсан чиг үүрэгтэй:

3.7.1.Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагад суралцагчдад эрт илрүүлэг хийсэн төлбөрийн нэхэмжлэлийн дагуу эрүүл мэндийн даатгалаас бүрэн санхүүжүүлнэ.

3.7.2.Суралцагчид эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг жил бүр төлөлт хийлгүүлэх, даатгалд бүрэн хамруулах ажлыг холбогдох чиг үүргийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

---oOo---

Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны 11 дугаар сарын 14-ны өдрийн 1105/А/2024 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

СУРАЛЦАГЧДЫГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ,
ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

